

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД:УАГ-ХОА-2021/45-20-ШТА-СА

Ховд хот
2021 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас:7043-2545 Цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn
Аудитор: Б.Должинжав
Утас:7043-2545 Цахим хаяг:doljinjav.b@audit.gov.mn
Аудитор: С.Оюунжаргал
Утас:7043-2545 Цахим хаяг:Oyunjargals@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдээгдэл аудит хийх үндэслэл.....	4-5
Ерөнхий мэдээлэл:.....	5
БҮЛЭГ 1: Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу бодиттой төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.....	6
1.1 Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 646.5 сая төгрөгийг хуваарилсан байна.....	6
1.2 Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.....	6
БҮЛЭГ 2: Сумдын сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.....	7
2.1 Сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулжээ.	7
2.2 Аймгийн сонгуулийн хороо нь сургалтын хоолны зардлыг давхардуулан гаргажээ.....	8
2.3 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ.....	9
2.4 Болзошгүй зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	9
2.5 Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.....	10
Дүгнэлт:.....	10
Зөвлөмж:.....	10-11
Аудитын тайлан баталсан тушаал.....	11
Холбогдох байгууллагын санал.....	12-16
Саналд өгсөн тайлбар.....	17

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХХОАТТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ААН	Аж ахуйн нэгж
УОК	Улсын онцгой комисс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сумдад олгосон санхүүжилт	7
Хүснэгт 2	Сонгуулийн зардлын тайлан	8-9
Хүснэгт 3	Болзошгүй зардлын тайлан	9

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8¹, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Ховд аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²-т заасныг баримтлан гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ: Сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн.

Үүнд:

- Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ: Аудитыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос Ховд аймгийн сонгуулийн хороодод хуваарилан, УБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан хэрэгжүүллээ. Аймгийн цагдаагийн газарт хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг ЦЕГ-т явуулсан тул аудитад хамруулаагүй болно.

АУДИТЫН АРГА ЗҮЙ: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА: Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, үе шатны хяналтыг аудитын

¹ Хуулийн 9.8-д Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын дээд байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Хуулийн 6.3. Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. шалгадагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Мөнхтулга, аудитор Б.Должинжав, С.Оюунжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 07 дугаар сарын 2 -наас 7 дугаар сарын 05-ны хооронд хэрэгжүүлнэ.

Талбарын үе шатны ажлыг 2021 оны 07 дугаар сарын 5-аас эхлүүлж, тайланг 2021 оны 08 дугаар сарын 06-ний дотор ҮАГ болон аймгийн сонгуулийн хороонд хүргүүлж аудитын хугацаанд албан хаагчдын ээлжийн амралт давхацсан тул 8 дугаар сарын 25-ны өдрөөр дуусгавар болгож хүргүүллээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Улсын Их Хурлаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс даган мөрдөж хэлсэн байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 14.1³-д заасны дагуу Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 40 тоот тогтоолоор Ховд аймгийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 15.1⁴-д заасны дагуу Ховд аймгийн сонгуулийн хорооны 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор 17 сумдын сонгуулийн хороог хороо бүр 7 гишүүнтэй байхаар байгуулж аймгийн сонгуулийн хорооны даргын Б/01 тоот захирамжаар бичиг хэргийн ажилтан, Б/02 тоот захирамжаар нягтлан бодогч нарыг томилжээ. 17 сумын сонгуулийн хороо, хэсгийн 91 хороотойгоор Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулжээ.

Сумдын сонгуулийн хороог 119, 91 хэсгийн хороог 715 нийт 843 төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулж аймгийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтад 54277 сонгогч бүртгэгдсэнээс 32929 сонгогч саналаа өгч, 60.7 хувийн ирцтэй оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁵-д заасны дагуу Ховд аймгийн сонгуулийн хороонд 646.5 сая төгрөгийн төсвийг хуваарилсан байна

Сонгууль зохион байгуулах зардлыг хуваарилахдаа холбоотой Сонгуулийн ерөнхий хорооноос зардал хуваарилах тухай 4 зөвлөмж өгөгдсөний дагуу аймаг сумдын сонгуулийн хороодод зардлыг хуваарилан зарцуулжээ.

Аймгийн сонгуулийн хороонд 4 удаагийн шилжүүлгээр нийт 646.5 сая төгрөгийг СЕХ-оос олгосноос 571.4 сая төгрөгийг 17 сумдын сонгуулийн хороонд, 75.1 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд тус тус зарцуулахаар хуваарилжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9.2⁶-т заасны дагуу Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 88.8 сая төгрөгийн санхүүжилтийг УБЕГ-аас хуваарилжээ.

³ Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 12.3-т заасны дагуу аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нийтэд мэдээлнэ. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд тухайн шатны цагдаагийн болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл орсон байна.

⁴ Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 12.3-т заасны дагуу сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

⁵ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ

⁶ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган баталж, улсын төсвөөс санхүүжүүлнэ

Бүлэг 1: Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу бодиттой төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилжээ.

Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 646.5 сая төгрөгийг хуваарласан байна.

- 1.1 Улсын Их Хурлаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс даган мөрдөж хэлсэн байна. Ховд аймгийн Сонгуулийн хороог СЕХ-ны 2021 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 40 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Аймгийн сонгуулийн хороо нь 17 сумдын сонгуулийн хороог 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот тогтоолоор 119 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд 17 сумын 91 хэсгийн хороотойгоор нийт 843 төрийн албан хаагч ажиллаж СЕХ-оос 646.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.
- 1.2 Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн 16-р тойрогт нийт 54277 сонгогч бүртгэгдсэнээс 32929 сонгогч саналаа өгч 60.7 хувийн ирцтэй оролцжээ. Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 1033 сонгогчийн саналыг авчээ. СЕХ-ны 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Хяналтын тооллого хийх журам”-ын дагуу 91 хэсгээс хяналтын тооллогыг зохион байгуулахад дүн зөрөөгүй байна.

Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.

- 1.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 646.5 сая төгрөгийг хуваарилж гүйцэтгэлээр 644.0 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 2.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт төвлөрүүлсэн.
- 1.4 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хүн амын тоо, газар нутгийн хэмжээг үндэслэсэн байна. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумдын сонгуулийн хороонд хуваарилан Аймгийн сонгуулийн хороо нь нийт төсвийн 11.6 хувь буюу 75.1 сая, сумдын сонгуулийн хороодод 88.4 хувь буюу 571.4 сая төгрөгийг хуваарилан зарцуулсан байна.
- 1.5 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн насны хүний тоо 2013 хүнээр нэмэгдэж хэсгийн хороо 1-ээр буурчээ. 2017 онд Буянт сум 6 хэсгийн хороотой байсан бол 2021 оны сонгуулиар 5 хэсгийн хороотой болж хэсгийн хорооны тоо нэгээр буурч бусад сумдын хэсгийн хорооны тоонд өөрчлөлт ороогүй байна.
- 1.6 Улсын бүртгэлийн хэлтэст Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан итгэмжлэгдсэн болон гэрээт ажилчдын урамшуулал, хоол унааны зардалд 50.5 сая, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэх зардалд 7.4 сая, сургалт зохион байгуулах зардалд 22.4 сая, техник хэрэгсэл тээвэрлэх, шуурхай багийн зардалд 8.5 сая нийт 88.8 сая төгрөг хуваарилсан байна.

Сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1 Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороонд 571.4 сая төгрөгийг хуваарилжээ. Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.

Д/д	Сумдын нэрс	Батлагдсан төсөв	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Үлэгдэл
1	Алтай сумын сонгуулийн хороо	29.1	29.1	0.0
2	Булган сумын сонгуулийн хороо	40.9	40.9	0.0
3	Буянт сумын сонгуулийн хороо	31.4	31.4	0.0
4	Дарви сумын сонгуулийн хороо	31.8	31.8	0.0
5	Дуут сумын сонгуулийн хороо	24.7	24.7	0.0
6	Дөргөн сумын сонгуулийн хороо	24.8	24.8	0.0
7	Жаргалант сумын сонгуулийн хороо	73.7	73.7	0.0
8	Зэрэг сумын сонгуулийн хороо	30.7	30.7	0.0
9	Манхан сумын сонгуулийн хороо	37.3	37.3	0.0
10	Мянгад сумын сонгуулийн хороо	29.6	29.6	0.0
11	Мөст сумын сонгуулийн хороо	29.8	29.6	0.2
12	Мөнххайрхан сумын сонгуулийн хороо	25.9	25.9	0.0
13	Үенч сумын сонгуулийн хороо	35.0	35.0	0.0
14	Ховд сумын сонгуулийн хороо	29.5	29.5	0.0
15	Цэцэг сумын сонгуулийн хороо	31.8	31.8	0.0
16	Чандмань сумын сонгуулийн хороо	34.7	34.7	0.0
17	Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо	30.6	30.6	0.0
	Нийт дүн	571.4	571.2	0.2

Сумдын сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлийг хянахад дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- СЕХ-ны ажлын албаны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/71 тоот албан бичгийн 6-д бараа ажил үйлчилгээ худалдан авсан е-баримтаа тухайн байгууллага хувь хүнээс хэвлэн авах гэж заасан ч 31.0 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа 10 сум нь е-баримтыг иргэн, ААН-үүдээс аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7⁷, Татварын ерөнхий хуулийн 28.5⁸ дахь заалтуудтай нийцэхгүй байна.
- СЕХ-ны ажлын албаны 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 3/124 тоот албан бичигт урамшуулал болон хоолны зардлыг төрийн албан хаагчдын цалингийн болон холбогдох дансанд нь шилжүүлнэ гэсэн боловч Булган, Дарви сумдын сонгуулийн хороо нь бэлнээр 51.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг гарган авч хэсгийн хороодод ажилласан албан хаагчдад олгожээ.
- 5 сумын сонгуулийн хороо нь жолоочийн тооцооны хуудас бодоогүйтэй, холбоотойгоор 14.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

⁷ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

⁸ Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй

- Сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 3 сумын сонгуулийн хороо нь ажилласан ажилчдад хоолны мөнгө олгосон боловч бусад хэмнэгдсэн зардлаас хоолны мөнгө давхардуулан гаргасан, хүнсний материал худалдан авсантай холбоотой 1.27 сая төгрөгийн зөрчил илэрлээ.
- Бараа, ажил үйлчилгээ хувь иргэнээс худалдан авахдаа е-баримт хэвлүүлэн аваагүй ХХОАТ суутгаагүйтэй холбоотой 0.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.
- Байр бэлтгэхтэй холбоотойгоор 5.6 сая төгрөгийн БҮТЭЗ зүйлийг худалдан авсан боловч ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй байна.

Аймгийн сонгуулийн хороо нь анхан шатны баримтгүй ажил гүйгээс санхүүжүүлжээ.

2.2 Аймгийн сонгуулийн хороо нь 72.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж 2.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Мэдээлэл технологийн баг, даамлын сургалтын зардлыг 1.2 сая, маягт хэвлүүлэх зардлыг 0.3 сая, бичиг хэргийн зардлыг 0.2 сая, шуудан холбооны зардлыг 0.5 сая, унааны зардлыг 0.2 сая, санал авах төхөөрөмжийг авах, буцаан хүргэж өгөх зардлыг 0.1 сая томилолтын зардлыг 0.1 сая, болзошгүй зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэжээ. Мэдээлэл технологийн баг, даамлын сургалтыг 2 өдрөөр төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 1 өдөр хийсэнтэй холбоотойгоор зардал хэмнэгдсэн байна. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг хянахад Аймгийн сонгуулийн хороо нь мэдээлэл технологийн баг, даамлуудын сургалтад 3.4 сая төгрөгийн хоолны зардлыг анхан шатны баримтгүй гаргасан алдаа зөрчил илэрлээ.

2.3 Аймгийн 17 сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүнээрээ нягтлан бодогчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлжээ. Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч 17 сумын сонгуулийн хорооны тайланг хүлээн авч нэгтгэн санхүүгийн тайланг гаргажээ. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 2		/сая төгрөгөөр/		
Зардлын нэр		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, Протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	0.3	-	0.3
2	Аймаг, сумын сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	14.6	14.5	0.2
3	Аймаг, сумын сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	17.2	16.8	0.4
4	Аймгийн сонгуулийн хорооны унааны зардал	53.2	53.0	0.2
5	Аймаг, сумын сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардал	4.7	4.7	-
6	Мэдээллийн технологийн баг, даамлын сургалтын зардал	12.3	11.1	1.2
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо унааны зардал	2.0	2.0	-
8	Санал авах байр Төрийн далбаа бэлтгэх зардал	29.1	29.1	0.0
9	Суртчилгааны зардал	5.0	5.0	-
10	Саналын хуудас санал тоолох төхөөрөмж авах буцаан хүргэх зардал	28.2	28.2	0.1
11	САС ашиглахтай холбоотой зардал/Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	4.1	4.1	-

12	Томилолтын зардал	6.8	6.8	0.1
13	Мэдээ дамжуулах зардал	3.5	3.5	-
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал хоолны зардал	401.7	401.7	-
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн даамлын урамшуулал хоолны зардал	53.7	53.7	-
16	Болзошгүй зардал	10.0	9.9	0.1
НИЙТ ДҮН		646.5	644.0	2.5

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажилласан байна.

2.4 Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ховд аймгийн 17 сумдаар ажиллаж сонгууль зохион байгуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгч ажиллажээ.

Аймгийн сонгуулийн хороо нь 4 баг болж 17 сумдын 91 хэсгийн хороодод 2 удаа очиж хяналт шалгалтыг хийж ажиллажээ. Тус шалгалтаар санал авах байрны тохижилт дутуу, санал авах өдөр эрчим хүчний тасалдалгүй найдвартай эх үүсвэрээр хангагдсан байдалд хяналт, Ковид-19 цар тахлын үед ажиллах заавар зөвлөмжийг өгч ажилласан байна.

Болзошгүй зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.5 Аймгийн сонгуулийн хороонд болзошгүй үйл ажиллагаанд зориулан 10 сая төгрөгийн болзошгүй зардлыг баталжээ. Болзошгүй зардлыг Мөст сумын 2 хэсгийн хороонд ажиллах төрийн жинхэнэ албан хаагчдаас Ковид-19 цар тахал илэрсэнтэй холбоотойгоор аймгийн сонгуулийн хорооны гишүүнээр ахлуулсан 25 албан хаагч 3 өдөр ажилласантай холбоотойгоор томилолтын зардал, хоолны зардал болон хөдөлмөр хамгааллын хувцас авах, 91 хэсгийн хороодод 1 өдөр ажилласан эмч нарын урамшуулалд зарцуулжээ.

Хүснэгт 3

№	Гүйлгээний утга	Зардлын нэр	Мөнгөн дүн
1	Томилолт/мөст ажлын хэсэг/	25 хүн өдрийн 50000	3.75
2	Хоолны зардал/мөст	25 хүн хоолны зардал 60000	1.50
3	Бээлий /Жаргалант хэсгийн хороод/	21400ш 1 удаагийн бээлий 45Төгрөг	0.96
4	Шатахуун /Мөст ажлын хэсэг болон жаргалант сумын хэсгийн хороод/	Мөст/ариутгал 1 машин ажлын хэсэг 3 машин/, жаргалант/ ариутгал 1 машин/	0.74
5	Нүүрний хаалт, бээлий, малгай /мөст ажлын хэсэг/	Мөст ажлын хэсэг	0.26
6	COVID-19 тэй холбоотой 91 хэсгийн хороодын эмчид урамшуулал	Бүх хэсгийн хороод /91 эмч 30000 төгрөг/	2.73
НИЙТ ДҮН			9.94

Улсын бүртгэлийн хэлтэс батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.6 Улсын бүртгэлийн хэлтэст Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан итгэмжлэгдсэн болон гэрээт ажилчдын урамшуулал, хоол унааны зардалд 59.6 сая, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэх зардалд 3.3 сая, сургалт зохион байгуулах зардалд 12.1 сая, техник хэрэгсэл тээвэрлэх, шуурхай багийн зардалд 13.8 сая нийт 88.8 сая төгрөгийг зарцуулсан боловч төлөвлөсөн арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.7 Урамшуулалт цалингаас 654.2 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутган тооцож, цалин дутуу бодож олгосон, мөн нягтлан бодогч өөрт олгогдох урамшуулалт цалингаас НДШ суутган тооцолгүйгээр бодож авсан зөрчил илэрлээ.

Аудитын явцад анхан шатны баримтын бүрдэл дутуу, иж бүрэн бус санхүүгийн баримттай мөн түүнчлэн Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл тайлан гаргаагүй шатахууны тооцоо бодоогүй зэрэг 15074.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- *Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу бодитой төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.*
- *Сумдын сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.*

Аудитаар нийт 107.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.12 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт бичиж, 107.08 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн сонгуулийн хорооны дарга Д.Энхболдод:

- Сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор худалдан авсан 5.6 сая төгрөгийн БҮТЭЗ, сонгуулийн хэсгийн хороодод хуваарилсан төрийн далбааг сумдын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгуулан ажиллах
- Е-баримтгүй ажил гүйлгээ гаргасан сумдын худалдан авсан бараа, ажил үйлчилгээний анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллах
- Бэлэн мөнгөөр ажилчдын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож Дарви, Булган сумдын ЗДТГ-ын дарга нарт хариуцлага тооцон ажиллах
- Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сумдын тайланг авахдаа дотоод хяналтыг хийж анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллах

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Хоролсүрэнд:

- Албан хаагчдын цалингийн дахин хийж, ХХОАТ-ын тооцооллын зөрүүг арилгаж

Аудитын тайлан баталгаажуулах тушаал:



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 17

Ховд

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар илэрсэн алдаа, зөрчил, акт, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн сонгуулийн хорооны дарга Д.Энхболд нарт тус тус хүргүүлж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсугай.

3. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг статистик мэдээний маягтын нэгтгэлд бүртгэж, хэрэгжилтийг бүрэн хангуулан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллахыг санхүүгийн аудитын багийн ахлах аудитор, Д.Мөнхтулга, аудитор Б.Должинжав, С.Оюунжаргал нарт, үр дүнг тооцон танилцуулахыг аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Х.БОЛДБААТАР

Холбогдох байгууллагын санал:


**ХОВД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
84000 Ховд, Ховд аймаг
Утас: 7043-2864 Факс: 976-7043-2864

2021.08.25 № 1/28
танай _____-ны № _____-т

Г ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны
ээлжит сонгуулийг зохион байгуулахтай
холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн
зардлын төлөвлөлт, зарцуулалтын гүйцэтгэлд
хийсэн "Аудитын тайлан"-гийн төсөлтэй танилцлаа.
Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн
зөвшөөрч байна.
Цаашид алдаа зөрчил давтан гаргахгүй байх
болно.


ДАРГА  ДЭНХБОЛД

00000053

Аудитын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛВОЛСОН УЛСЫН ТӨСВӨӨС САХУУЖУУЛСАН ЗАРДЛЫН ТӨЛӨВӨЛӨГТ, ЗАРДУУЛАЛТ, ТҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ Аудитын код: /ХОА-2021/45-20-ШТА-СА/

Хавсралт 3

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд бүртгэлийн төсөл

Байгууллагын нэр: Аймгийн сонгуулийн хороо

Д/д	Аудитын чиглэл/сүүлт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мөнгөн төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
А	1	3	4	5	6	7
1		Аймгийн сонгуулийн хороо анхын шатны баримтгүй ажил гүйцэтгэх санхүүжүүлсэн бүртгэл, Дарга сүмийн сонгуулийн хорооны гишүүдийн урьдчилуул, холбоны мөнгийг бэлтгээр авч олгосон.	3,360.0	Зөвлөмж		Зөвлөмж
2		Аугтай, Бүлгэн, Дарга, Манган, Даргач, Мөнхсайраг, Үенч, Хода, Мөст, Эрдэнэдүрэн сүмийн сонгуулийн хороод хэсгийн хорооны бидр тохижуулах, бичиг хэргийн материал, шатахуун худалдан авахад 31.0 сая төгрөгийг зарцуулсан ч НӨАТ-ын баримтаар баталгаажуулаагүй анхын шатны бүрэн бүр баримтаар гүйцэтгэж байсан байна.	51,100.0	Зөвлөмж		Зөвлөмж
3		Сүмийн хэсгийн хороод нь бидр тохижуулах зардалаас 5.59 сая төгрөгөөр БҮТЗЗ-ийг худалдан авахад зарцуулсан ч сүмийн ЦДТТ-ын данс бүртгэлд бүртгээгүй.	31,000.0	Зөвлөмж		Зөвлөмж
4	Зардлыг хууль, журамд нийцүүлэн зарцуулалтын дагуу үр ажилтай, хэмжээтэй зарцуулсан уу?	Бүртгэл сүм 1.96 сая, Дарга сүм 1.13 сая, Үенч сүм 3.72 сая төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан боловч жолоочийн замын худалдсугүй, Чандмань 4.26 сая, Даргач сүм 2.83 сая төгрөгийн шатахууныг жолоочийн замын худалдсугүй бодож тооцогдоогүй олгосон, Жаргалант сүм 0.16 сая, Манган сүм 0.3 сая, Мөст сүм 0.26 сая төгрөгийн хүнсний материал авч доржуулалт бүр зарцуулсан.	5,589.0	Зөвлөмж		Зөвлөмж
5		Мангад сүмийн хэсгийн хорооны гишүүдэд олгосон шүүдэн холбооны зардалаас ХХСОАТ сүүтгэлгүй, Дарга, Бүртгэл сүмд бараа, ажил үйлчилгээг хуль хүнээр гүйцэтгүүлэхдээ НӨАТ-ын баримтгүй ХХСОАТ сүүтгэлгүй олгосон	14,720.0	Зөвлөмж		Зөвлөмж
6		Манган сүм 0.26 сая, Мөст сүм 0.26 сая төгрөгийг хэсгийн хороодын хоолны мөнгийг бүрэн хувиарилж олгосон боловч бусад хэмнэгдсэн зардалаас давхардуулан гаргаж төсвийн үрэлтэн зарцуулсан	139.0	Зөвлөмж		Зөвлөмж
7		Манган сүм 0.26 сая, Мөст сүм 0.26 сая төгрөгийг хэсгийн хороодын хоолны мөнгийг бүрэн хувиарилж олгосон боловч бусад хэмнэгдсэн зардалаас давхардуулан гаргаж төсвийн үрэлтэн зарцуулсан	553.7	Зөвлөмж		Зөвлөмж
			109,481.7			

Бэлтгэсэн: Аудитор: /С.Сүхмэргэл/ Төнийцэх зөвшөөрсөн: /Д.Энхболд/

Анхын шатанд хянгын: Аудитын менежер: /А.Цэдэвсрэн/ Аймгийн сонгуулийн хорооны дарга: /Б.Энхмандал/

Хоёр дахь шатанд хянгын: Дарга, Тэргүүлэх аудитор: /Х.Сүхбаатар/ Нэгтгэн бодогч: /Б.Энхмандал/



**ХОВД АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

84141 Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг,
Засаг даргын тамгын газрын байр,
Утас/Факс: (976) 7043 4388, 7043 2888,
И-мэйл: khovd@burtgel.gov.mn, Вэбсайт: ho.burtgel.gov.mn

2021. 08. 18 № 454

танай _____-ны № _____-т

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

2021 оны Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын Тайлангаар илэрсэн алдаа зөрчлийг аудитын явцад засаж залруулах хүсэлтэй байгаа тул алдаа зөрчлийн нэгтгэлээс хасаж өгнө үү.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА С.ХОРОЛСҮРЭН



Хавсралт 3

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн төсөл

Аудитын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБСГ ЛДСОН УЛСЫН ТӨСӨВӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВӨЛГТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ Аудитын код: ХОА-2021/45-20-ШТА-СА

Байгууллагын нэр: Улсын бүртгэлийн хэлтэс

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн төвн утга	Мөнгөн дүн (Мөнгөн төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалтгаалач санал, тайлбар	Гаргасан шийдэл
A	1	3	4	5	6	7
1	Зардлыг хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан уу?	Урамшуулалт цалингаас 654.2 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутган тооцож, цалин дутуу бодож олгосон	654.2	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх
2		Нягтлан бодлогч өөрт олгогдох урамшуулалт цалингаас НЦШ суутган тооцолгүйгээр бодож авсан	123.7	Төлбөрийн акт	Зөвшөөрсөн	Төлбөрийн акт
			777.9			

Бэлтгэсэн:

Анхны шатанд үнэлсэн:

Хоёр дахь шатанд үнэлсэн:

Аудитор:

Аудитын менежер:

Дарга, Төргүүлэх аудитор:

Тамгилдаж зөвшөөрсөн:

Улсын бүртгэлийн хэлтэсийн дарга

Нягтлан бодлогч

И.С. Хроолсүрэн

И.А. Цыцэгсүрэн

Н.С. Хроолсүрэн

Н.С. Хроолсүрэн



Аудитаар илэрсэн алдаа, зөрчил

№	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр	Шалгагч байгууллагын санал
1	Урамшуулал цалингаас 654.2 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутган тооцож цалин дутуу бодож олгосон	654.2	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн
2	Нягтлан бодогч өөрт олгохдох урамшуулалт цалингаас НДШ суутган тооцолгүйгээр бодож авсан	123.7	Төлбөрийн акт	Зөвшөөрсөн
3	Нягтлан бодогч нь зарим томилолтын тооцоо бодолт хийж баримтжуулаагүй, түүнчлэн зарим томилолтыг удирдах албан тушаалтнаар хаалгаагүй, томилолтоор ажилласан он сар өдөрт тэмдэглээгүй, тайлан, илтгэх хуудасгүй зэрэг хүчин төгөлдөр бус байхад томилолт олгосон	424.0	Зөвлөмж өгөх	Аудитын явцад алдаа зөрчлийг арилгах
4	Бараа материал, шатахуун худалдан авах, ачаа тээврийн хөлс төлөхдөө цахим Е баримтаар баталгаажаагүй баримтаар гүйлгээ хийж хөрөнгө зарцуулсан	6,471.7	Зөвлөмж өгөх	Аудитын явцад алдаа зөрчлийг арилгах
5	Сонгуулийн үйл ажиллагаатай холбогдох бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, тайлан гаргаагүй илүү дутуу гаргасан тооцоо бодлоогүй байна. Мөн нярав зарлалын баримт бичиж зарлага гаргаж хэвшээгүй, бичиг хэргийн зарим материалыг няравын нэрээр шаардах хуудас бичиж зарлага гаргасан байна.	3,318.3	Зөвлөмж өгөх	Аудитын явцад алдаа зөрчлийг арилгах
6	Нягтлан бодогч нь шатахууны тооцоо бодож хянаагүй түүнчлэн анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангагдаагүй байхад гүйлгээ хийж хөрөнгө зарцуулсан	4,860.0	Зөвлөмж өгөх	Аудитын явцад алдаа зөрчлийг арилгах

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Д/д	Ирүүлсэн санал, тайлбарын утга	Шийдвэрлэлт
1	Анхан шатны баримтын бүрдэлгүй, иж бүрэн бус баримтыг бүрдүүлж, Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл тайлан гаргаж аудитын явцад алдаа зөрчлийг арилгах	Анхан шатны баримтын бүрдлийг хангуулж тайлан тооцоог гаргуулан 15074.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан тул алдаа зөрчлийн нэгтгэлээс хасав.